

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН,
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ							
1	2.2. Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ	2.2.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ	2021-2025		<ul style="list-style-type: none"> - Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь - Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь - Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь 	Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог шинэчлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/139 дүгээр тушаалаар “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”-ыг баталж, хүн амын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж, ЭМДСангаас санхүүжүүлэх журмыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолоор баталж, хэрэгжүүлж эхэлсэн. Иргэдийг дараах 6 насны бүлгийн багцын дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> 1. 0-5 насны багц; 2. 6-17 насны багц; 3. 18-30 насны багц; 	90.0 НЭМГ, ХӨХ, ХБӨХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>4. 31-45 насны багц; 5. 46-60 насны багц; 6. 61-ээс дээш насны багц.</p> <p>18-30 насны иргэд 60,000 төгрөгийн 12 нэр төрлийн багцын үзлэг, шинжилгээ, оношилгоо хийлгэх бол 31-45 насныхан 130,000 төгрөг, 46-60 насныхан 150,000 төгрөг, 61-ээс дээш насны иргэд 140,000 төгрөгийн багцын үзлэг, шинжилгээ, оношилгоо тус тус хийлгэнэ. Энэхүү эрт илрүүлэгт 2022 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 60.8 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөсөн бөгөөд 2022 оны эхний 11 сарын байдлаар 73 эрүүл мэндийн байгууллагад 7.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 2022 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар 765,264 хүнийг хамруулаад байна.</p>	

					<p>Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - КОВИД-19, сармагчны цэцэг зэрэг Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийн дагуу мэдээлж, “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” хэмээн зарласан халдварт өвчний эрсдэлийн үнэлгээг УОК, ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ болон бусад холбогдох байгууллагууд хамтран зохион байгуулж хэвшсэн. 2022 онд КОВИД-19-ын эрсдэлийн үнэлгээг 1, сармагчны цэцэг өвчний эрсдэлийн үнэлгээг 3 удаа тус тус хийж, эрсдэлийг бууруулах зөвлөмж гарган, хэрэгжүүлж байна. - Шуурхай удирдлагын нэгжийг 11 аймаг (Баян-Өлгий, Ховд, Увс, Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор, Орхон, Сүхбаатар, Архангай)-т байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж захиалж, нийлүүлж эхлээд байна. - Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ)-ийн эзэмшлийн газрын баруун хойд хэсэгт 0.58 га. талбай бүхий Улаанбаатар хотын төв цэгээс 10 км зайд, Сонгинохайрхан, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сонсголонгийн замын дагуу газарт шинэчлэн барьж, ашиглалтад оруулсан. Эрүүл мэндийн сайдын 	
--	--	--	--	--	--	--

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/331 дүгээр тушаалаар агуулахын тоног төхөөрөмжийг орлогод авч хуваарилан үндсэн хөрөнгийн бүртгэлд авсан байна.</p> <p>- Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс бүрдүүлэхэд анхаарч, АХБ, Япон Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан, Олон талт хамтын ажиллагааны КОВАКС механизмын хүрээнд нийт 41.4 тэрбум төгрөгийн эм, хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж хүлээн авч, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан. Эдгээр арга хэмжээний дүнд товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь 2022 оны эхний 10 сарын байдлаар 93.4, Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь 2022 оны эхний 11 сарын байдлаар 94.4, Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь 2022 оны эхний 11 сарын байдлаар 93.1 тус тус байна.</p>	
2		2.2.1. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг, боловсролыг дээшлүүлж, үндэсний	2021-2025		- 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт улсын хэмжээнд 765,264 хүн хамрагдсанаас 351,006 буюу 45.9 хувь нь эрэгтэйчүүд, 414,258 буюу 54.1 хувь нь эмэгтэйчүүд байна.	70.0 НЭМГ, УСХЗХ, ХБӨХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
		түвшинд нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрх илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.			<ul style="list-style-type: none"> - 1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа - 10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл - Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь - Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь - Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь 	<p>Өвчлөлийн 459,688 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 279,071 буюу 60.7 хувь нь хоол боловсруулах тогтолцооны өвчин, 39,869 буюу 8.7 хувь нь дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, 32,616 буюу 7.1 хувь нь зүрх судасны тогтолцооны өвчин, 30,081 буюу 6.5 хувь нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 27,991 буюу 6.1 хувь нь амьсгалын тогтолцооны өвчин бүртгэгдсэн нь тэргүүлэх шалтгаан болж нийт өвчлөлийн сэжигтэй тохиолдлын 89.1 хувийг эзэлж байна.</p> <p>0-17 насны хүүхдүүдийн дунд өвчлөлийн 214,096 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн тохиолдлоос шүд цоорох 154,271 буюу 72.1%, шүдний гажиг 6,223 буюу 2.9%, хараа муудах 2,757 буюу 1.3%-ийг эзэлж тэргүүлэх өвчлөл болж байна. Бүртгэгдсэн шүд цоорох өвчний 127,354 тохиолдол буюу 82.6%-ийг 6-17 насны хүүхэд эзэлж байна.</p> <p>2022 оны эхний 11 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 728 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 12.2 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.8 пунктээр өссөн.</p> <p>2022 оны эхний 11 сарын байдлаар улсын хэмжээнд эхийн эндэгдлийн 20 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 33.5 ногдож байна. Өнгөрсөн</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>оны мөн үеэс 44 тохиолдлоор буюу 100 000 амьд төрөлтөд 62.9-оор буурсан. Улсын хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар вируст гепатитийн өвчлөл 10,000 хүн амд 0.6 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. 2022 оны эхний 11 сарын байдлаар артерийн гипертензийг эрт илрүүлэх үзлэгт 18-аас дээш насны нийт 1,173,637 (56.0%) хүн хамрагдсаны 40.4 хувь нь эрэгтэй, 59.6 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.9 хувьд артерийн гипертензи онош батлагдсан нь өмнөх оны мөн үеэс 0.4%-иар нэмэгдсэн.</p> <p>Харин чихрийн шижин өвчний эрт илрүүлэх үзлэгт 35-аас дээш насны нийт 958,017 (76.0%) хүн хамрагдсаны 40.3 хувь нь эрэгтэй, 59.7 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувьд чихрийн шижин өвчний онош батлагдсан.</p> <p>Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралт 23.9 хувьтай байна.</p> <p>Эрүүл мэндийг дэмжих сан нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай. 2022 оны байдлаар 11 дүгээр сарын байдлаар хүн амыг</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагаанд Эрүүл мэндийг дэмжих сангаас нийт 1,761,680,710 төгрөгийн санхүүжилт олгосон байна.	
3		2.2.3. Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин суугаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.	2021-2025			Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн салбарт UpToDate олон улсын тусламж, үйлчилгээний удирдамжийн цахим платформыг нэвтрүүлэн, эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын багц цагийн 1/3-ийг платформоос бүрдүүлэх боломжтой болсон. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 45,112 хэрэглэгч платформыг ашиглаж байгаа нь сар бүр платформ хэрэглэгчдийн тоо тогтмол нэмэгдэж байгаа үзүүлэлттэй байна (2022 оны 08 дугаар сар 25,254, 09 дүгээр сар 36,209, 10 дугаар сар 44,009 хэрэглэгч). Платформын талаар 2022 онд зохион байгуулсан 2 удаагийн сургалтад 1,132 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан (төр, хувийн хэвшил, нийслэл, орон нутаг) байна. Тархи, мэдрэл, зүрх судас, үе мөч, бөөр, уушги, чих хамар, хоолойн зарим өвчин, эмгэг болон нярайн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр оношилгоо, эмчилгээний орчин үеийн	90.0 ЭТҮГ, УАУХ, АЛШТХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, эх орондоо бүрэн оношлох, эмчлэх боломжийг бүрдүүлэх талаар санаачлагатай ажиллаж байна. Үүнд: Төрөлхийн, шалтгаан тодорхойгүй нурууны мурийлт оноштой үйлчлүүлэгчид дурангийн мэс ажилбар хийх технологи, Хүзүүний нугалмын хугарал мултралыг арын хүрцээр дагз ястай бэхлэх мэс ажилбар, Тохойны үе бүтэн солих мэс ажилбар, “Цусны бүлэг өөр донор”-оос элэг шилжүүлэн суулгах мэс ажилбар, Мөрний үе солих мэс ажилбар, хиймэл үе хагас солих мэс ажилбар, нээлттэй мөр эргүүлэгч булчингийн шөрмөсний гэмтлийн мэс ажилбар, мөрний үений холбоос сэргээх мэс ажилбар, дурангаар мөр эргүүлэгч булчингийн шөрмөсний урагдал засах мэс ажилбар, Бага хүрцийн буюу дурангийн мэс заслын технологийг нэвтрүүлэхээр дэлүү авах мэс ажилбар, нэг портоор цөсний хүүдий авах мэс ажилбар, дурангаар фондопликаци хийх мэс ажилбар, дурангаар элэгний мэс ажилбар, Кадавер яс болон шөрмөс ашиглан төрөлхийн согог болох Genu recurvatum-г засах мэс ажилбар, өвдөгний үений төрөлхийн мултралыг нэг мэдээ алдуулалтаар өвдөгний үений дотор булууг хэсэгчлэн солих, ард, урд чагтан</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>холбоосыг кадавер шөрмөс ашиглан сэргээх, саран жийргэвчийг сэргээн засах мэс ажилбар, өвдөгний үений тойгны холбоос сэргээх мэс ажилбар, Бөөр шээсний замын чулууг лазер аппаратаар эмчлэх эмчилгээний технологи, Шээсний доод замын хөдлөл зүйн, үргүйдлийн эмгэгийг оношлох, шинжлэх шинжилгээний арга, Тархины судасны катетерт ангиографийн шинжилгээ, Тархины судасны өнгөт хэт авиа дуплекссонографийн шинжилгээ, Судсан дотроос спазмолитик эмчилгээ, Нурууны L1 түвшний АВМ-ийг судсан дотроос бөглөх мэс ажилбар, Транс-ораль хүрцээр С2, С3-ийн нугасны буглааг нээх ажилбар болон бусад аргууд болно.</p> <p>Уушги орлуулагч ЭКМО аппаратыг ашиглан 2022 оны 10 дугаар сарын байдлаар УНТЭ 22, УГТЭ 2, ХӨСҮТ 1, ЦТЭ 5, нийт 30 хүнд эмчилгээ хийж, эмчилгээний үр дүн 61.5 хувь байна.</p> <p>Хүүхдийн мэдрэл, мэдрэлийн мэс засал, хүүхдийн сэргээн засалч эмч нарын баг ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн мэдрэлийн эмгэг судлалын кабинетийн хяналтад байдаг саа, саажилттай 230 хүүхдэд идэвхитэй диспансерын хяналтын үзлэг хийж, доод мөчний саатай, мэдрэлийн ёзоор тайрах мэс засал хийх заалттай 22</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>хүүхэд, мөн 4 мөчний саатай, эцэг, эх нь мэдрэлийн ёзоор тайрах мэс засал хийлгэх хүсэлтэй 67 хүүхдэд хүүхдийн мэдрэл, мэдрэлийн мэс засалч эмч нарын баг үзлэг хийж, MRI шинжилгээнд хамруулсан. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд мэдрэлийн ёзоор тайрах мэс заслыг Турк Улсын мэдрэлийн мэс заслын багтай хамтран 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үе шаттай нэвтрүүлж байна. Энэ хүрээнд 5 хүүхдэд мэс заслыг амжилттай хийж, мэс заслын дараах сэргээн засах эмчилгээ хийгдэж байна. Мөн энэхүү тусламж, үйлчилгээг нутагшуулах зорилгоор УГТЭ, ЭХЭМҮТ, УНТЭ-ийн мэдрэлийн эмч нарыг ажлын байран дээрх сургалтад, харин мэдрэлийн мэс заслын 1 эмчийг Турк Улсад богино хугацааны сургалтад хамруулсан байна.</p> <p>2022 оны 12 дугаар сард УНТЭ, УХТЭ, ХСҮТ-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Япон Улсын Alfresa брэндийн IS-Prime загварын өтгөнд далд цус илрүүлэх иммунологийн анализаторыг хүлээлгэн өгчээ. Монгол Улсын хувьд энэ төрлийн сүүлийн үеийн оношилгоог хувийн эрүүл мэндийн байгууллагууд л үзүүлдэг байсан бол энэхүү тоног төхөөрөмжтэй болсноор улсын лавлагаа шатлалын эмнэлгүүд</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>оношилгоо, эмчилгээний нэр төрлөө нэмэгдүүлж, иргэдэд чирэгдэлгүйгээр шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлж, нарийн, бүдүүн гэдэсний хавдрыг эрт үед нь илрүүлэн оношилж, эмчилгээнд хамруулах боломж бүрдэж байна.</p> <p>Мөн дараах томоохон оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Алло-трансплантац буюу донороос үүдэл эс шилжүүлэн суулгах технологийг нэвтрүүлэх; - Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний чиглэлээр молекул генетикийн технологиудыг нэвтрүүлж, нутагшуулах; - Нарийн гэдэсний дурангийн оношилгоог нэвтрүүлэхээр ажиллаж байна. <p>Гадаад улсад оношилгоо, эмчилгээ хийлгэхээр явах иргэдийн урсгалыг бууруулах зорилгоор УГТЭ нь оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тосгуурын фибрилляцийн үеийн хөлдөөх аблаци эмчилгээ; 2. Зүрхний 3D цахилгаан зураглал бүхий ахисан түвшний аблаци эмчилгээ; 	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>3. Гол судасны графт стент суулгах эмчилгээг хийж эхэлсэн байна. Хавдар судлалын үндэсний төвд Австри Улсын Засгийн газрын хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Хорт хавдрын навигац болон стереотактик эмчилгээний төв байгуулах” төслийн хүрээнд 2022 онд өндөр нарийвчлалтай шугаман хурдасгуур аппарат суурилуулахтай холбоотойгоор тархи, нугасны хавдрын стереотактик туяа эмчилгээг 2023 онд хийж эхлэх бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>Улсын төсвийн санхүүжилт (нэгж үнэ 1.7 тэрбум төгрөг)-ээр Германы Siemens үйлдвэрийн Artis Zee маркийн Ангиографийн аппаратыг Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн БОЭТ, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг 6 аймагт суурилуулан Зүрхний ишеми, Цочмог шигдээс, Элэгний хавдрын үед хийгдэх TACE эмчилгээ, Тархины судасны оношилгоо, Диализийн туннель, Хөлийн тараагуур судасны оношилгоо зэрэг тусламж, үйлчилгээг хийж байна. Ангиографийн аппаратыг орон нутагт суурилуулснаар иргэдийг оношилгоонд эрт хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл рүү чиглэсэн төвлөрлийг сааруулах, иргэдийг оршин суугаа газартаа, эх орондоо оношлуулах, эмчлүүлэх</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>боломжийг нэмэгдүүлж, иргэдэд үүсэх санхүүгийн эрсдэлийг бууруулж байна. Мөн орон нутагт өмнө нь оношлох боломжгүй байсан, ялангуяа хол зөөвөрлөх боломжгүй тархи, нугас, зөөлөн эдийн гэмтлийн үед тухайн газар нь тусламж, үйлчилгээг үзүүлдэг болсон нь ихээхэн ахиц дэвшил юм. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/123 дугаар тушаалаар Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлгийн 6 их эмч УГТЭ-т судсан дотуурх оношилгоо, эмчилгээний төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалтын хөтөлбөрийг бүрэн дүүргэж, тархи, зүрх судасны ангиографийн оношилгоо, эмчилгээ хийх чадамж эзэмшжээ.</p> <p>Мөн 64 зүслэгтэй компьютер томографын аппаратаар 6 аймагт (Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг) хөрөнгө оруулалт хийсэн (8.2 тэрбум төгрөг).</p> <p>УАУ-ны тусламж, үйлчилгээг хослуулан хөгжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, үр дүн, нотолгоо судалгааг дэмжих, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх, экспортод гарах гарцыг</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>тодорхойлоход “Уламжлалт анагаах ухааны салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв: Асуудал, шийдэл” улсын зөвлөгөөнийг БШУЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, ХНХЯ, бусад төр, хувийн хэвшлийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангасан цахим болон тэнхим хосолсон хэлбэрээр 2022 оны 06 дугаар сард зохион байгуулж, УАУ-ны салбарыг хөгжүүлэхэд цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа тодорхойллоо.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/104 дүгээр “Журам, гэрээний загвар, шалгуур үзүүлэлт батлах тухай” тушаалд Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд уламжлалтын тусламж, үйлчилгээний шалгуурыг тусгайлан тусгасан, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/55 дугаар тушаалаар Уламжлалт анагаах ухааны өвчний ангилал, оношийн кодыг шинэчлэн батлуулсан. Уламжлалт анагаах ухааны бие даасан оношийн ангилал, өртөг зардал тодорхой болж, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд УАУ-ны оношилгоо эмчилгээний бүртгэл тоон мэдээллийн сан үүсэж, зонхилон тохиолдох өвчлөл, эмчилгээний нэгдсэн мэдээлэл гарах боломжийг бүрдүүллээ. УАУ-ны эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>сайжруулахад чиглэсэн сургалтад орон нутагт УАУ-ын дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төр, хувийн хэвшлийн 40 гаруй эрүүл мэндийн байгууллагын төлөөлөлийг хамруулав. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/445 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индексд уламжлалт анагаах ухааны төгсөлтийн дараах сургалтын үндсэн мэргэшлийн 6, төрөлжсөн мэргэшлийн 13 индекс батлагдсан. Үндсэн мэргэжлийн 8 чиглэлийн хөтөлбөрийг боловсруулж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж ЭМХЗ-ийн 26-33 дугаар тогтоолоор батлуулснаар лавлагаа шатлалын эмнэлэгт Уламжлалт анагаах ухааны төрөлжсөн мэргэшлээр ажиллах хүний нөөцийн сургалтын цөм хөтөлбөртэй болсон. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/55 дугаар тушаалаар Уламжлалт анагаах ухааны өвчний ангилал, оношийн кодыг шинэчлэн батлуулан УАУ-ны оношилгоо, эмчилгээний бүртгэл тоон мэдээллийн сан үүсгэж, зонхилон тохиолдох өвчлөл, эмчилгээний нэгдсэн мэдээлэл гарах боломжийг бүрдүүлсэн.</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэлд УАУ-ны эмнэлзүйн болон уламжлалт эмийн чанар аюулгүй байдлыг сайжруулах чиглэлийг тусгажээ.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/208 дугаар тушаалаар “Эмийн чанар аюулгүй байдлыг судлах” дэд ажлын хэсэг байгуулж, эмийн бүртгэлийн Licemed эмийн бүртгэлийн программд бүртгэлтэй уламжлалт эмийн судалгааг хийж байна. Уламжлалт эмийн үйлдвэрүүдэд эмийн үйлдвэрийн зохистой дадал (GMP)-ыг хангуулахад чиглэсэн сургалтыг зохион байгуулж, дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдэх юм. Уламжлалт анагаах ухааны эмийн 7 ерөнхий хэлбэрээр (талх эм, тан эм, амирлуулах эм, архин эм, тосон эм, үнсэн эм, зуурмал эм) фармокопейг боловсруулж, 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Хүний эмийн фармокопейн хороогоор ҮФӨ 0444:2022, ҮФӨ 0443:2022 эмийн түүхий эдийн фармокопейн өгүүллийг баталгаажуулсан.</p> <p>Эрүүл мэндийн яамнаас Монгол хүний оюуны үнэ цэнэ шингэсэн уламжлалт анагаах ухааны бүтээл туурвилыг</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						гадаад, дотоодын түүхэн сурвалжаас нэгтгэн эмхэтгэн нийтийн хүртээл болгох үйл ажиллагааг дэмжин 39 ботийг түгээхэд бэлэн болгожээ. УАУ-ны эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн сургалтыг 2022 онд 3 удаа зохион байгуулж, нийт 360 гаруй орон нутгийн болон нийслэлийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын төлөөллийг хамруулжээ.	
4		2.2.4. Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.	2021-2025	307.2 сая төгрөг (ДЭМБ) 5.9 тэрбум төгрөг (улсын төсөв)		Осол, гэмтэл ихээр гардаг Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хөвсгөл аймгийн Хатгал, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Булган аймгийн Хутаг өндөр, Архангай аймгийн Тариат, Ховд аймгийн Булган, Завхан аймгийн Их-Уул, Орхон аймгийн Баян-Өндөр, Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Мандал сум зэрэг 10 цэгт яаралтай тусламжийн жишиг цэгийг байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийн худалдан авалтыг ДЭМБ-ын санхүүжилтээр хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/502 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад тоног төхөөрөмжийг хуваарилсан (255.9 сая төгрөг). Яаралтай тусламжийн эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхийг сайжруулах зорилгоор 2022 оны 12 дугаар сарын 17-19-ний өдөр “Сумын	100.0 ЭТҮГ, АЛШТХ СЭЗГ, ХОХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>эрүүл мэндийн төвөөс үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж, орон нутгийн 40 гаруй эмч, сувилагч хамрагдсан (51.3 сая төгрөг).</p> <p>ОХУ-ын Москва хотноо тус улсын Эрүүлийг хамгаалах яамны харьяа Хүүхдийн анагаах ухааны эрдэм шинжилгээний үндэсний төвд “Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх зарчмууд” сэдэвт сургалтад Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Өргөө амаржих газраас нийт 15 эмч 2022 оны 07 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд оролцсон. БНХАУ-ын Хунань мужийн хүүхдийн эмнэлгээс зохион байгуулж байгаа, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлсэн Яаралтай тусламжийн сувилахуйн 3 долоо хоногийн цахим сургалтад 21 аймаг, нийслэлийн яаралтай тусламжийн 25 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж байна.</p> <p>2022 онд 21 аймаг, лавлагаа шатлалын ЭМБ, нийт 73 эрүүл мэндийн байгууллагад 81 ширхэг түргэн тусламжийн автомашин олгосон байна (Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/197, А/254, А/317, А/364, А/581, А/603, дугаар тушаал). Үүнд:</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>Алсын зайн болон яаралтай тусламж, үйлчилгээнд ашиглах туулах чадвар өндөртэй түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв зэрэг лавлагаа шатлалын 5 эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн хөгжлийн төв зэрэг нийт 27 эрүүл мэндийн байгууллагад 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгожээ. Мөн түргэн тусламжийн УАЗ-фургон автомашиныг 11 аймгийн 22 сумын эрүүл мэндийн төвд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгож ашиглалтад оруулжээ.</p> <p>БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Улаан загалмай байгууллагаас хандивласан Сөрөг даралтат түргэн тусламжийн 2 автомашиныг Монголын улаан загалмай нийгэмлэгээс 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр ЭМЯ-нд хүлээлгэн өгсөн. “КОВИД-19” халдварын үед өвчтөн тээвэрлэх зориулалттай иж бүрэн тоноглогдсон энэхүү 2 автомашиныг ХӨСҮТ-д хуваарилсан байна. Уг машин дотор эмнэлгийн яаралтай анхны тусламжийн</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						багаж, тоног төхөөрөмжийг суурилуулж өгсөн байна. Үүнд All6000S брендийн амьсгалын аппарат, Aricon брендийн зүрхны цахилгаан бичлэгийн 12 сувагтай аппарат, дефибриллятор, хяналтын дэлгэц зэрэг зүйлс багтжээ. Япон Улсын Засгийн газраас Хөгжлийн төлөвлөлтийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн коронавируст халдвар (КОВИД-19)-ыг эмчлэх, урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд 8 ширхэг иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашиныг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгчээ.	
5		2.2.5. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл	2021-2025		- Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь - Иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээл, ядууралд өртөх эрсдэлийг бууруулсан хувь	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 328 сумын ЭМТ, 208 ӨЭМТ, лавлагаа шатлалын 64 эмнэлгийн байгууллагад гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нэвтэрсэн. ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор ЭМДСангаас санхүүжүүлэх 562 оношийн хамааралтай бүлгийг 705 болгож, амбулаторийн тусламж, үйлчилгээ, өдрийн мэс засал, ажилбар, эмчилгээг даатгалаас санхүүжүүлэхээр жагсаалтыг өргөжүүлсэн. Мөн “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн	70.0 СЭЗГ, СДХ ТЗУГ БТГ, СУХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
		<p>мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.</p>				<p>журам"-ыг шинэчлэн ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор батлуулж анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний санхүүжилтийн уялдаа холбоог хангасан байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 239 хувийн хэвшлийн ортой эмнэлгийн 196 буюу 82.0 хувьтай нь ЭМДЕГ-аас гэрээ байгуулан ажиллаж байна. 2022 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас төр, хувийн хэвшлийг 2,370 эрүүл мэндийн байгууллагад 1,745,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан байна. ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор 650 нэр төрлийн "Өндөр өртөг бүхий мэс заслын тусламж, үйлчилгээний хэрэгсэл"-ийн зардлыг тусад нь санхүүжүүлж, зардлын 25 хувийг иргэн төлдөг байсныг өөрчилж, үндсэн мэс заслын өртөгт нь шингээж цогцоор нь санхүүжүүлдэг болгож иргэнийг санхүүгийн эрсдлээс хамгаалсан. Хамгийн өндөр үнэтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болох эрхтэн шилжүүлэх үйлчилгээний нийт зардал (113.6 сая төгрөг)-ын 75 хувийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. 2021 онд өндөр өртөгтэй дуран, компьютер томографи, MRI оношилгоо, 2022 онд шинээр цөмийн оношилгоо, эмчилгээ</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>болох ПЭТ-компьютер томографи оношилгоо, Иод-131 эмчилгээ, хорт хавдрын бай эмчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлж өргөжүүлсэн. Өндөр өртөгтэй оношилгоо, эмчилгээний тодорхой хувийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх нь иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулахад үр дүнтэй юм.</p> <p>Эрүүл мэндийн сайд аймаг, нийслэлийн Засаг даргатай 2022 онд байгуулсан гэрээнд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ТУЗ байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ЭМЯ-тай хамтран ажиллах заалтыг тусгасан. 2022 онд Өвөрхангай аймаг дахь БОЭТ, Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ шинээр байгуулагдан ажиллаж эхэлсэн. Дорнод аймаг дахь БОЭТ, Архангай, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэгт ТУЗ байгуулах сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дууссан. Дундговь, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан-Уул, Завхан, Сүхбаатар аймгийн НЭ, Орхон, Өмнөговь, Ховд аймаг дахь БОЭТ-үүдэд ТУЗ байгуулах үйл ажиллагаа эхэлж, хамт олны буюу ТББ-ын төлөөлөл сонгон шалгаруулах аль нэг үйл ажиллагаанууд явагдсан.</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						Эрүүл мэндийн багц хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулах чиглэлийн дагуу төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэгт ТУЗ байгуулах ажлыг үргэлжлүүлээгүй байна.	
6		2.2.6. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.	2021-2025			Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/129 дугаар тушаалаар “Телемедициний үндэсний сүлжээний ажиллах журам”-ыг шинэчлэн батлуулан хэрэгжүүлж байна. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн солилцооны платформ /НІЕР/ нь нийт эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглаж байгаа програм хангамжид хадгалагдаж байгаа иргэний эрүүл мэндийн мэдээллийг нэгтгэн дамжуулах програм хангамж юм. Энэхүү програм хангамжийн хөгжүүлэлтийг Дэлхийн банкны санхүүжилттэй "Цахим эрүүл мэнд" төслийн туслан гүйцэтгэгч “Аксис системс” ХХК хийж гүйцэтгэсэн. Платформыг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс лавлагаа шатлалын 48 эмнэлэгт нэвтрүүлсэн ба 2022 оны 12 дугаар сарын байдлаар ЭМДЕГ болон 535 анхан шатны эмнэлэг, Медсофт И-клиник, Вингс, Гиганет, Карте зэрэг эмнэлгийн мэдээллийн систем хөгжүүлэгч байгууллагуудын систем ашигладаг 50 гаруй хувийн эрүүл мэндийн байгууллага, нийт 700 гаруй байгууллага НІЕР системд холбогдсон.	100.0 БТГ, СТХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						НIEP-ээр дамжин өвчтний цахим түүх "E-kart" үүсч эхэлсэн. Алсын зайн анагаах ухааны МН кардио програм хангамжийг ЭМЯ-ны Техникийн хороо болон Мэдээллийн технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж ашиглах шийдвэр гарсан. Уг системийг анхан болон лавлагаа шатлалын 264 эрүүл мэндийн байгууллагын 574 хэрэглэгч ашиглан телемедицинээр тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Мөн ЭХЭМҮТ, УНТЭ, УХТЭ, УГТЭ, ГССҮТ, ХӨСҮТ, ЦТЭ, ЭНЭҮТ-II зэрэг 8 эрүүл мэндийн байгууллагын эрчимт эмчилгээний тасаг телемедициний "IE" мэдээллийн системийг ашиглаж байна.	
7		2.2.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2025			Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаарыг 80 байхаар баталсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 378 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын 28, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эмийн хяналтын лабораторийн 24, нийт 52 албан хаагчийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт орон тоо, цалингийн сан,	90.0 БТГ, СУХ ЭТҮГ, ЭТҮЧАБХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>холбогдох зардлын хамт 2021 оноор тасалбар болгон шилжүүлэх арга хэмжээ авахыг Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд нарт даалгасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тоог 132 болгон нэмэгдүүлсэн. Засгийн газрын 222 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/450 дугаар тушаалаар “Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.</p>	
8		2.2.8. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн үр чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.	2021-2025			<p>Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэлх төлөвлөлт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн удирдамжийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар батлуулж, төгсөлтийн өмнөх, дараах сургалтаар бэлтгэх тогтолцоо, нийгмийн баталгааны өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, 2026 он хүртэлх эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээг тооцоолох ажил хийгдэж байна. мэргэжил, мэргэшлээр гаргасан.</p>	<p>70.0</p> <p>БТГ, СУХ</p> <p>ТЗУГ</p>

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>Үндсэн мэргэжлийн 8 чиглэлийн хөтөлбөрийг боловсруулж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж ЭМХЗ-ийн 26-33 дугаар тогтоолоор батлуулснаар лавлагаа шатлалын эмнэлэгт Уламжлалт анагаах ухааны төрөлжсөн мэргэшлээр ажиллах хүний нөөцийн сургалтын цөм хөтөлбөртэй болсон. Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээний хүрээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 271 эмчийг ажлыг байранд сургасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Бөөр, шээсний замын дурангийн мэс засал судлалын мэргэжил дээшлүүлэх 1 сарын сургалтад 15 аймгийн бөөрний мэс заслын 15 эмч, 15 сувилагч (14 хоног ажлын байранд), 2. Ангиографийн тоног төхөөрөмж, компьютер томографийн аппаратаар хангагдсан 5 аймгийн 6 эмчийг УГТЭ-т ангиограф/судсан дотуурхи эмчилгээ, оношилгоо судлалын 1 жилийн сургалтад 2022 оны 01 сард элсэн суралцаж төгссөн байна. 3. УГТЭ-ийн Харвалт шигдээсийн баг нь Орхон аймгийн БОЭТ, Булган аймгийн нэгдсэн эмнэлэгт сургалт зохион байгуулж, сургалтад 14 эмч хамрагдсан. 	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>5. Монголын Хэт авиан оношилгооны нийгэмлэгтэй хамтран хэвлийн хөндийн хэт авиан оношилгооны 3 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг ажиллан суралцах хөтөлбөрөөр орон нутагт 2 удаа зохион байгуулж, Хөвсгөл аймгийн 28 сумын ЭМТ-ийн 30 эмч, Өвөрхангай аймгийн сум, өрхийн 30 эмч, нийт анхан шатны 60 эмчийг сургасан байна.</p> <p>6. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, оношилгооны хэвлийн болон бамбайн хэт авиа, дурангийн оношилгоо хийх эмч нарт зориулсан онолын сургалтыг цахимаар зохион байгуулж, дүрс оношилгооны 55 эмч, дурангийн 78 эмч хамрагджээ.</p> <p>8. Аймаг, нийслэлийн дүрс оношилгооны эмч нарын дадлага сургалтыг УНТЭ-ийн Эрүүл мэндийг дэмжих төвд, дурангийн дадлага сургалтыг Интермед, Монгол-Япон эмнэлэг, Сонгдо болон Орхон аймгийн Медипас эмнэлэгт тус тус зохион байгуулсан. Энэхүү сургалтад Сүхбаатар, Говьсүмбэр, Архангай, Өмнөговь, Ховд, Булган, Дорнод зэрэг 7 аймаг, 9 дүүргийн 28 дурангийн эмч, сувилагч хамрагдсан байна.</p> <p>Япон Улсын ЖАЙКА хамтын ажиллагааны байгууллагын “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>сургалтыг сайжруулах төслийн хүрээнд Сувилахуйн сургагч багш бэлтгэх 3 хоногийн сургалтыг 2 удаа зохион байгуулж, сургалтад сувилахуйн төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Дархан-Уул, Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн сувилагч нар хамрагдаж, сувилахуйн мэргэшүүлэх сургалт удирдах багшаар бэлтгэгдсэн. Түүнчлэн “Сувилахуй, эх барихуйн төгсөлтийн дараах сургалтын чадавхыг сайжруулах сургалт”-д ЭМЯ, ЭМХТ, УХТЭ, Орхон аймгийн БОЭТ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, Өргөө, Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн нийт 17 сувилагч, эх баригч нарыг 2 ээлжийн сургалтад хамруулсан байна.</p> <p>Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн үр чадварыг сайжруулах хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаалаар “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл”-ийг баталсан. Урт хугацааны гадаад сургалтад 11 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>- Аппло-үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ чиглэлээр 6 эмнэлгийн</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>мэргэжилтэн 30 хоногийн хугацаагаар 2 удаагийн ээлжээр;</p> <ul style="list-style-type: none"> - Зүрхний хавхлага солих судсан дотуурх мэс засал чиглэлээр 3 эмнэлгийн мэргэжилтэн 60 хоногийн хугацаагаар; - Инвазив бус пренатал тест чиглэлээр 2 эмнэлгийн мэргэжилтэн 30 хоногийн хугацаагаар тус тус байна. <p>Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор эрүүл мэндийн ажилчдын цалингийн доод жишгийг шинэчлэн тогтоож, эрүүл мэндийн байгууллагууд эмч, ажилчдын цалинг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Хархорин сум нь эмч, ажилчдын үндсэн цалинг 10-25 хувиар нэмэгдүүлж, улирал бүр урамшуулал, Хавдар судлалын үндэсний төв эмч, ажилчдынхаа үндсэн цалинг 43 хүртэл хувиар нэмэгдүүлэхээс гадна 15 хүртэлх сая төгрөгийн урамшуулал, Гэмтэл, согог судлалын үндэсний төв эмч, эмнэлгийн ажилчиддаа 500.000 төгрөгийн урамшуулал олгож, сувилагч нарын үндсэн цалинг 10-25 хувиар нэмсэн, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв 2021 онд нийт ажилчдынхаа цалинг 30 хувь нэмэгдүүлсэн бол 2022 онд гүйцэтгэлтэй нь уялдуулан 20 хувь нэмэгдүүлсэн байна. Амгалан амаржих</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						газар 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эмч эмнэлгийн ажилчдын цалингаа 10-20 хувиар нэмсэн байна. УНТЭ гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнд 2022 онд 33 эмч, ажилтандаа орон сууцны урьдчилгаа болох тус бүр 30 сая хүртэлх төгрөг олгосон, УГТЭ нийт ажилчидынхаа үндсэн цалинг 40 хувиар нэмэгдүүлжээ. Эмч, ажилчдынхаа үндсэн цалинг нэмэхийн зэрэгцээ орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн ЭМТ-ийн 17 ажилтанд орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд 30.0 сая төгрөг, 20 ажилтанд орон сууцны зээлийн хөнгөлөлтөд 20.0 сая төгрөг, 11 ажилтанд монгол гэр тус бүр олгосон байна.	
9	2.5. Эрүүл баталгаат орчныг бий болгоно	2.5.4. Эрүүл мэнд болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгож бэхжүүлнэ.	2021-2025			Орчны эрүүл мэндийн тандалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах ажлын хүрээнд Orchin.Xcloud программд ЦУОШГ-аас ирүүлсэн Улаанбаатар хотын агаарын 4 үндсэн бохирдуулагчийн нийт 2000 гаруй тоон мэдээллийг хүлээн авч нэгтгэдэг болсон. Тандалтын тогтолцоонд нэгтгэгдэж буй орчны эрүүл мэндийн үзүүлэлтүүдэд БОАЖЯ-ны харьяа Цаг уур, орчны шинжилгээний газраас Агаар бохирдуулагч 4 үзүүлэлт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ундны усны	50.0 НЭМГ, УСХЗХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>бохирдлын 5 үзүүлэлт, хөрсний бохирдлын 4 үзүүлэлт, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс хүн амын өвчлөл, нас баралтын мэдээлэл зэрэгт үндэслэн харилцан хамаарлыг гарган үнэлгээ, дүгнэлт өгч “Орчны эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2021 он, 2022 оны товхимлыг гарган олон нийтийн хүртээл болгож байна. Мөн БОАЖЯ-тай хамтран Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага болон Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвтэй хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн тандалтын программыг шинэчилэн сайжруулах чиглэлээр тендер зарлан ажлын даалгаврыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/585 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх журам”, “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх байгууллагыг сонгон шалгаруулах журам” шинэчлэн батлуулжээ. Эрүүл мэндийн сайдын 2020 он А/401 дүгээр тушаалаар эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны явц, хяналт, үр дүн, тайланд дүгнэлт өгөх үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						баталсан бөгөөд 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр ГССҮТ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ зэрэг байгууллагын төлөөлөл орсон зөвлөлийн анхдугаар хуралдааныг зохион байгуулсан байна.	
10	2.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ.	2.7.2. Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ.	2021-2025			<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/159 дүгээр тушаалаар “Цусны хатаасан толбонд нярайн скрининг шинжилгээ хийх заавар”, “Нярайн скрининг шинжилгээгээр төрөлхийн гипотиреоз өвчнийг илрүүлэх заавар”, “Нярайн скрининг шинжилгээгээр адреногениталь хамшинжийг илрүүлэх заавар”-ыг тус тус батлуулан хэрэгжүүлж байна.</p> <p>БНХАУ-ын Энхтайван, найрамдлын сангийн 500.0 мянган ам.долларын санхүүжилтээр Перинатологийн төв байгуулах төслийг дэмжүүлж 2021 оны 12 дугаар сард гэрээ байгуулсан. Перинатологийн төв байгуулах бэлтгэл ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ЭНЭҮТ-II-д удамзүйн лабораторид ашиглах 27 нэр төрлийн 1,513,000,000 төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч суурилуулсан. - Эхийн цусанд ургийн гажиг илрүүлэх хоёрол, гурвал сорилын дааврууд 	50.0 ЭТҮГ, АЛШТХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>болох β-hCG, PAPP-A, AFP, uE3 зэргийг тодорхойлж байна.</p> <p>Анагаахын удамзүйн лаборатори нь 2012 оны 12 дугаар сард үүсгэн байгуулагдаж, хромосомын буюу цитогенетикийн лаборатори, молекул-генетикийн лаборатори, биохими-генетикийн лаборатори гэсэн үндсэн хэсэгтэйгээр үйл ажиллагааг явуулж байна.</p> <p>ЭХЭМҮТ-ийн Анагаахын удамзүйн лабораторид 2022 онд 5,273 үйлчлүүлэгч, удам зүйн зөвлөгөө өгөх кабинетад 1,286 үйлчлүүлэгч хандан зөвлөгөө авчээ.</p> <p>- 2022 онд зонхилон тохиолдох хромосомын эмгэгтэй хүүхэд төрүүлэх эрсдэлийг жирэмсний эрт хугацаанд тодорхойлох пренатал илрүүлэг шинжилгээг 4,469 жирэмсэн эмэгтэйд хийж, 48 эмгэг илрүүлсэн байна.</p> <p>- 2022 онд хромосомын эмгэгийн эрсдэл өндөр тодорхойлогдсон 15-20 долоо хоногтой жирэмсэн эмэгтэйн шаардлага хангасан 321 ураг орчмын шингэн хүлээн авч шинжилсэн. Онош тодруулах зорилгоор пренатал оношилгоонд хамрагдаж 48 хромосомын өвчнийг оношилж, гэр бүлтэй зөвлөлдөн жирэмсний асуудлыг шийдвэрлэсэн.</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						- 2022 онд заалт бүхий үйлчлүүлэгчид хромосомын тоо, бүтцийн өөрчлөлтийг тодорхойлох зорилгоор хромосомын бүрдэл тодорхойлох G-banding шинжилгээг 483 үйлчлүүлэгчид хийж, 143 хоромосомын эмгэг илрүүлж, тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.	
11		2.7.4. Хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг бий болгоно.	2021-2025			"Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай" хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг дахин боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/456 дугаар тушаалаар батлуулсан. 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдөр Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, мэргэжилтнүүдийн дунд "Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай хууль"-ийн төслийг танилцуулж, хуулийн төсөлд санал авсан. Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай" 01 дүгээр тогтоолын 3 дэх хэсэгт зааснаар "Хүний генетикийн оношилгоо, эмчилгээ, генийн сангийн аюулгүй байдлыг зохицуулах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, УИХ-д 2023 онд багтаан өргөн мэдүүлэх" гэж тусгасан. Энэхүү ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/175 дугаар тушаалаар	30.0 ЭТҮГ, АЛШТХ БТГ, СУХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						“Хүний генетикийн тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Хүний генетикийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, үр нөлөөний судалгаа, тандалт судалгаа; хуулийн төслийн зардлын тооцоог олон улсын туршлага, үнэлгээ, харьцуулсан судалгаа; хуулийн төслийг бусад улс орны туршлагатай харьцуулан судалгаа зэрэг ажлыг ажлын хэсэг хийсэн байна. Мөн хуулийн төслийн хувилбарыг ЭМЯ-ны Анагаахын ёс зүйн хяналтын хорооны гишүүдэд танилцуулан, хэлэлцүүлж, саналыг авсан.	
НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ							
12	8.3. Хөдөө, аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.	8.3.5. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжинэ.	2021-2025			2024 онд Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Төв аймагт 33 орон тоо бүхий “Зоонозын өвчин судлалын төв” болон хилийн 12 боомтод 8 орон тоо бүхий “Тандалтын нэгж”-ийг тус тус байгуулж, Ховд, Увс, Өмнөговь, Дундговь, Архангай аймгийн “Зоонозын өвчин судлалын төв”-д барилга, байгууламж барихад шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэх” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1а/5053 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Харин ЗГХЭГ-аас 2022 оны	30.0 НЭМГ, ХӨХ, УСХЗХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>12 дугаар сарын 08-ны өдрийн ХЭГ/2957 тоот албан бичгээр тандалтын нэгжийг хууль тогтоомжид нийцүүлэн байгуулах асуудлыг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргатай зөвшилцөж шийдвэрлэх, Зоонозын өвчин судлалын төвийг тухайн аймгийн Эрүүл мэндийн газрын санал, дүгнэлт, хэрэгцээ, шаардлагад үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэж тогтоолын төслийг буцаасан байна.</p> <p>Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймагт ЗӨСТ байгуулах талаар үндэслэл, танилцуулга, шаардагдах төсвийг 2023 оны төсвийн төсөлд тусгасан ч 2023 онд шинээр барилга байгууламж барихгүй шийдвэртэй холбоотой хойшилсон.</p> <p>АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Дорнод аймгийн Хавирга, Увс аймгийн Боршоо, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтод тандалтын нэгж байгуулах үндэслэл, танилцуулга, санхүүжилтийн тооцоог хийж хүргүүлсэн бөгөөд төслийн Удирдах хорооны хурлаар дэмжигдэж, АХБ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд 2023 онд нийлүүлэгдэхээр болсон.</p> <p>Хүний болон малын эрүүл мэндэд нөлөөлж буй эмэнд тэсвэртэй бичил</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						<p>биетнийг тандах, түүнтэй тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, нянгийн эсрэг эмийн хэрэглээг хянах, бичил биетний тэсвэржилтийн талаарх хүн ам болон хүн, малын эрүүл мэндийн салбарын ажилтны мэдлэг, хандлагыг сайжруулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/255, А/137 дугаар хамтарсан тушаалаар “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022-2025 оны хэрэгжүүлэхээр баталсан.</p> <p>Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Зоонозын өвчин судлалын үндэсний төв хамтран хүн, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах “НЭГ ЭРҮҮЛ МЭНД” бодлогын үнэлгээний салбар хоорондын үндэсний хэлэлцүүлгийг ДЭМБ, ДМАЭМБ, НҮБ-ын ХХААБ-ын дэмжлэгтэйгээр 2022 оны 06 дугаар сарын 15-17-ны өдөр зохион байгуулж, эрүүл мэнд, малын эмнэлэг, байгаль орчны салбарын үндэсний болон орон нутгийн мэргэжилтнүүд, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, нийт 100 гаруй</p>	

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						төлөөлөгч оролцжээ. Хэлэлцүүлгийн үр дүнд Монгол Улсад хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлсон салбар хоорондын хамтарсан төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна.	
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ							
13	9.1. Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	9.1.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай, бүсчилсэн сүлжээг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана.	2021-2025			Улсын хэмжээнд нийт 4,952 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 13, тусгай мэргэжлийн төв 3, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг 6, эрүүл мэндийн төв 9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сумын эрүүл мэндийн төв 321, өрхийн эрүүл мэндийн төв 208, бусад 12, ортой хувийн эмнэлэг 239, хувийн клиник 1,548 байгууллага үйл ажиллагаа явуулж эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна (Эрүүл мэндийн үзүүлэлт 2021, Эрүүл мэндийн хөгжлийн төв). Улсын хэмжээнд Орхон, Дорнод, Өвөрхангай, Ховд, Өмнөговь аймагт Бүсийн оношилгоо, эмчилгээний төв бүсийн хамрах хүрээний аймаг, сумын хүн амд лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж байна. Орон нутгийн хүний нөөцийн чадавхийг сайжруулах, бэхжүүлэх, төвлөрлийг	50.0 БТГ, СУХ ЭТҮГ, АЛШТХ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцах газар, хэлтэс
						сааруулах, төгсөлтийн дараах сургалтын чанарыг сайжруулах зорилгоор Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрлийг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын 5, 6, 7 дугаар тогтоолоор олгосон. 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад Өвөрхангай 3, Өмнөговь 1, Ховд 2 резидент, нийт 6 эмч элсүүлэн сургаж байна. Өмнөх онд сургалт эрхлэх зөвшөөрөл авсан Орхон 3, Дорнод 3, нийт 6 эмчийг элсүүлэн сургаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад дээрх 5 Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд нийт 12 резидент эмчийг сургаж байна.	
ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ						68.5	

Эрүүл мэндийн яам
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
2022 оны 12 дугаар сар